

Богд банк ХК-ны олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

2022 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Богд банк нь 2021 оны 12 сард Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон худалдах зөвшөөрлөө авч 31,750 сая төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн билээ.

Банк нь энэхүү татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дунд хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж, банкны үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр зарцуулахаар төлөвлөсөн ба үнэт цаасны танилцуулгад тусгаснаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

/сая төгрөгөөр/

№	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛ	ОН			ЧИГЛЭЛ	ХУВЬ
		2021	2022	2023		
1	Технологийн хөрөнгө оруулалт	2,540	7,303	2,858	12,700	40%
2	Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт	1,905	3,810	3,810	9,525	30%
3	Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт	2,778	3,523	3,224	9,525	30%
	НИЙТ	7,223	14,636	9,891	31,750	100%

Банк нь татан төвлөрүүлсэн хөрөнгөө 3 жилийн хугацаанд буюу 2023 оныг дуустал хугацаанд зарцуулж дуусахаар анх төлөвлөсөн бөгөөд 2023 оны 06 сарын 30-ний өдрийн байдлаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг төлөвлөгөөнд тусгасан чиглэлийн дагуу холбогдох зарцуулалтыг хийн ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын төрөл бүрийг задлан гүйцэтгэлийг тайлант хугацаагаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалтын төрөл	Төлөвлөгөөт дүн	Зарцуулсан дүн	Гүйцэтгэлийн хувь
1	Технологийн хөрөнгө оруулалт	12,700	2,275	17.91%
2	Бүтээгдэхүүн үйлчилгээ, хөгжүүлэлт	9,525	9,525	>100.0%
3	Борлуулалтын сувгийн хөгжүүлэлт, сайжруулалт	9,525	3,791	39.80%
НИЙТ		31,750	15,591	49.10%

Хөрөнгө оруулалтын төрөл бүрийг банкны үнэт цаасны танилцуулгад дурдсан чиглэл болон төрлөөр илүү задлан холбогдох гүйцэтгэлийг доорхи хэсэгт дэлгэрүүлэн танилцуулья.

II. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НАРИЙВЧИЛСАН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

1. ТЕХНОЛОГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Банк нь технологийн хөрөнгө оруулалтад нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 40 хувийг зарцуулахаар төлөвлөсөн ба үүний 50 хувийг цахим бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд, 33 хувийг үндсэн томоохон систем сайжруулалт хөгжүүлэлтэд, үлдсэн 17 хувийг одоо байгаа бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагааг сайжруулахад тус тус зарцуулахаар төлөвлөсөн билээ. Тайлант хугацааны байдлаар тус төрлийн хөрөнгө оруулалтын задаргаа дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Технологийн хөрөнгө оруулалтын зарцуулалтын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Хөрөнгө оруулалтын задаргаа	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
1	Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ	6,350	1,288	20.28%
2	Систем сайжруулалт хөгжүүлэлт	4,191	829	19.78%
3	Уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээг цахимжуулах, сайжруулах	2,159	158	7.30%

2. БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ ХӨГЖҮҮЛЭЛТ, САЙЖРУУЛАЛТ

Банк нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн 30 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүний 75 хувийг онлайн зээлд,

үлдсэн 25 хувийг шинэ зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд зарцуулахаар төлөвлөсөн. Банк нь энэхүү хөрөнгө оруулалтын төрөлд зарцуулах эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан болно.

Хүснэгт 4. Бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэлтийн зарцуулалт

/сая төгрөгөөр/

№	Зарцуулалтын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
1	Онлайн зээл	7,144	26,919	>100.0%
2	Шинэ зээлийн бүтээгдэхүүн	2,381	35,026	>100.0%
3	Бусад судалгаа идэвхжүүлэлт		79.15	

3. БОРЛУУЛАЛТЫН СУВГИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ, САЙЖРУУЛАЛТ

Банк нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн мөн адил 30 хувь буюу 9.5 тэрбум төгрөгийг борлуулалтын сувгийн хөгжүүлэлт сайжруулалтанд зарцуулахаар төлөвлөсөн. Банк нь тайлант хугацаанд шинэ салбар байгуулах үйл ажиллагаанд нийт 3,791 сая төгрөгийг зарцуулаад байна.

Хүснэгт 6. Банкны салбарын тоо



Банк нь тайлант хугацаанд борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх, чанаржуулах тал дээр анхааран ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацааны байдлаар 13 салбартай үйл ажиллагаа явуулж байна.

Банк нь энэ онд шинээр 4 салбар байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд “Их тойруу” салбар 2023 оны 07 сард үйл ажиллагаа эхлүүлэхээр болоод байна.